

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА



МОНГОЛ УЛСЫН “БАЙНГА ТӨВИЙГ САХИХ” БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЯТАД, МОНГОЛЫН ХАРИЛЦААНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ ТОВЧ ӨГҮҮЛЭХ НЬ*

*Л.Түмэнцэцэг***

*Ш.Амжилт****

***Abstract:** Mongolia, which is an import northern neighbor country of China, put forward of idea of implementing foreign policy of “Permanent Neutrality” in September 2015. This article focuses on the background, purpose of Mongolia’s “Permanent Neutrality” policy and its possible impact to China from perspective of national security strategy and economy.*

***Key words:** Mongolia; Permanent Neutrality; China-Mongolia Relations*

* * *

Монгол улс бол Хятадын умард талд орших чухал хөрш болно. 2015 оны 09-р сарын 07-ны өдөр, Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Байнгын төвийг сахих” бодлоо илээр дурдан гаргасан байна. Дараа нь, 09-р сарын 29-ний өдөр, Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж НҮБ-ын 70-р Ассемблейн хуралд илтгэл тавихдаа Монгол Улс “Байнгын төвийг сахих бодлого”-ыг хэрэгжүүлнэ гэж тунхагласан бөгөөд олон улсын хамтын нийгмийг хүлээн зөвшөөрч дэмжихийг уриалсан байна. Уг илтгэлийн агуулгыг англи, хятад, франц, солонгос, япон, араб зэрэг хэлээр орчуулж, гадаадад суугаа элчин сайдын яамнаараа дамжуулан холбогдох улсуудад өргөнөөр сурталчлав¹. Монгол улс “Байнгын төвийг сахих улс” гэдгийг дурдан гаргасан нь нэг цагийн хийрхэл биш, тэр нь “Эвсэлд үл нэгдэх” гадаад бодлоготой гарал үүсэл нэгтэй юм.

Монгол улс “Байнгын төвийг сахих бодлого” дурдан гаргасан түүхэн үндэслэл

Монгол улс 1921 онд Ардын Хувьсгал ялснаас нааш, хялбар бусаар олж ирсэн Үндэсний тусгаар тогтнол-оо яаж бэхжүүлэх бол Монголын гадаад харилцааны бодлогын үйл ажиллагааны хамгийн чухал зүйл болж ирэв. Дэлхийн хоёрдугаар дайны дараа, Монголын тусгаар тогтнолын байдал нь олон улсын нийгэмд аажмаар хүлээн зөвшөөрөгдсөн боловч ЗХУ-ын хяналтаас мөн салж чадаагүй

* Фондын төсөл: Боловсролын Яамны Хүмүүнлэг, Нийгмийн Шинжлэх Ухааны баазын төсөл “Монгол Улсын улс төрийн байдлын хувиралт болон Хятад, Монголын харилцааны хөгжлийн хандлагын судалгаа” (11JJD810019), Боловсролын яамны философи нийгмийн шинжлэх ухааны судалгааны тусгай итгэмжилсэн төсөл “Хятад Монголын харилцааны судалгаа” (12JF024) төслийн бүтээл.

** ӨМИС-ийн Монгол улсыг судлах хүрээлэнгийн Профессор

*** ӨМИС-ийн Монгол улсыг судлах хүрээлэнгийн Ахлах багш

¹ Монгол улс яагаад “Байнгын төвийг сахих улс” болох хүсэлтэй вэ, хүлээн зөвшөөрөгдөх эсэх нь ажиглах шаардалагатай. Дэлхийн дахин сонин, 2015. 10. 22

байлаа. 1990 онд Зүүн Европын огцом хувиралт, ЗХУ-ын задралын дараагаар Монгол улс сая жинхэнээр тусгаар тогтнож бие даасан хөгжлийн замаар замнаж эхэлсэн байна. Дараа нь, “хэт нэг талыг барьсан” гадаад бодлогыг хэрэгжүүлж ЗХУ-ын хяналтанд 70 гаруй жил байсан гүнзгий түүхэн сургамжинд суурилан, Монгол улс гадаад харилцааны бодлогоо дахин боловсруулсан байна. 1990 онд, Монгол Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга О.Очирбат БНХАУ-д айлчлав. Монголын удирдлага тушаалд гарсны дараа анхны айлчлалаа БНХАУ-ыг сонгосон нь Монгол улсны гадаад харилцааны бодлого мөн чанарын хувиралт гарсныг харуулж байгаа юм. Түүхийн шинэ цаг үед, Монгол улс зөвхөн ЗХУ, Зүүн Европын улсуудтай харилцахыг хүндэтгэж байсан бодлогоо хаяж, АНУ, Япон, Герман зэрэг өрнөдийн хөгжсөн орнууд, Ази, Номхон далайн орнууд, хөгжиж байгаа орнууд болон олон улсын байгууллагуудтай найрамдалт харилцаа хамтын ажиллагаа өрнүүлэхийг хүндэтгэн үзсэн байна. Энэ нь Монгол улсын “Эвсэлд үл нэгдэх” гадаад харилцааны бодлогын үзэл баримтлалыг харуулсан. Монгол улсын Ардын их хурлын баталсан “Монгол улсын гадаад харилцааны бодлогын үзэл баримтлал”-д, Монгол улс нээлттэй, эвсэлд үл нэгдэх гадаад харилцааны бодлого хэрэгжүүлж, “ОХУ болон БНХАУ-тай найрамдалт харилцаа байгуулах нь Монгол улсын гадаад харилцааны бодлогын тэргүүн чухал чиглэл” гэж чухалчилж, Орос Хятадтай “Тэнцвэртэй харилцаж, өргөн дэлгэр найрамдалт хөршийн харилцаа хөгжүүлнэ” гэжээ. 2011 оны шинээр баталсан “Гадаад харилцааны үзэл баримтлал”-д түрүүчийн үзэл баримтлалын агуулгыг үндсэндээ хадгалсан бөгөөд шинэ байдлын дагуу нөхвөр оруулсан байна. “Нээлттэй, эвсэлд үл нэгдэх гадаад харилцааны бодлого”-оо “Энх тайван, нээлттэй, тусгаар тогтносон, олон тулгуурт гадаад харилцааны бодлого” болгон тэлэн өргөтгөж, гадаад харилцааны бодлогын нэгдмэл чанар болон тасралтгүй чанарыг чухалчилжээ. Гадаад харилцааны бодлогын тэргүүн чухал үүрэг бол ОХУ, БНХАУ хоёр хөрштэй найрамдалт харилцаа хөгжүүлж, “Гуравдахь хөрш”-ийн бодлогыг албан ёсоор “үзэл баримтлал”-даа оруулсан байна. “Гуравдахь хөрш”-ийн бодлого гэдэг нь Монгол улсын гадаад харилцааны бодлогын нэг удаагийн “инновац” болно. “Гуравдахь хөрш”-ийн онгод бол нүүдэлчдийн уламжлалт оюун ухаанаас эхлэлтэй, монголчууд тал нутагт тулга тулахдаа гурван чулуугаар тулдаг нь алгебрын “наад зах нь гурван цаг байж нэг хавтгай болдог” гэдэг эггийн санаа болно. Иймээс, гуравдахь этгээдэд элсвэл сая Монгол улсын гадаад харилцааны бодлогын тэнцвэрт байдлыг хадгалж, Монгол улсын аюулгүй орчныг баталж чадна гэж Монгол улс үздэг. Хятад Орос хоёр улсын дунд хавчигдсан жижиг гүрэн, нэг талаар энэ хоёр том хөрштэйгөө найрамдалт харицаа хөгжүүлж, нөгөө талаар АНУ, Япон, БНСУ, Энэтхэг зэрэг улстай “Гуравдахь хөрш”-ийн гадаад харилцаагаа тэлэн өргөжүүлж, мөн Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, НАТО, Ази, Номхон далайн хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын байгууллагыг “Гуравдахь хөрш”-ийн гадаад харилцааг ахиулах гол чиглэл болгож, Хятад Орос хоёр том гүрний харилцаагаа тэнцвэржүүлэхийн хамт, олон тулгуурт гадаад харилцаагаараа Хятад Орос хоёр улстай харилцах гадаад харилцаагаа тэнвэржүүлэх гэсэн байна. Монгол улсын эдгээр бодлого нь том гүрнүүдийг тохиолыг амжуулан өөрийн нөлөөллөө

өргөтгөх ажлыг ахиулжээ. БНХАУ, ОХУ, АНУ, Япон Монгол улстай харилцаагаа чухалчилсан нь даруй Монгол улсын “Олон тулгуурт” гадаад харилцааны бодлогыг амжилттай хэрэгжсэнтэй холбоотой мөртөө бас шинэ зуунд ЗХА-ийн аюулгүй байдалын дэглэмд Монгол улсын стратегийн үнэ цэнэ дээшилсэнтэй холбоотой байж, холбогдох улсуудын ашиг сонирхол болон аюулгүй байдлын харилцааг харуулсан байна. Үүний зэрэгцээ, Дэлхийн баялаг өдөр ирэхүйеэ хомсдож байгаа байдал доор, Монгол улсын дэлхий дэх стратегийн байр суурь өдөр ирэхүйеэ дээшилж, НАТО-гийн улсууд, тухайлбал Канад, Герман болон НАТО-гийн түнш улс Австрали, БНСУ-ын Монгол улс дахь ашиг сонирхол өдөр ирэхүйеэ дээшилж байгаа нь НАТО-гийн улсууд Монгол улстай цэргийн аюулгүй байдлын хамтын ажиллагаа өрнүүлэхэд эдийн засгийн суурь тавьж, Монгол улс ч НАТО, Европын аюулгүйн зөвлөл зэрэг олон улсын байгууллагын анхаарах этгээд болсон байна.

Олон улсын шинэ байдал доор, том гүрнүүдийн интерактив олширч, хамтын ажиллагаа болон маргаан тасрахгүй байна. АНУ Японы холбоо шинээр орон байраа тогтоож, Хятад Америкийн Ази Номхон далайн бүс нутаг дахь өрсөлдөөн ив илхэн болж, Хятадын Өмнөд далай болон түүний хөрш зэргэлдээ улсуудын аюулгүй байдлын тогворгүй байдал даамжирч байна. Ялангуяа Украины асуудлын талаарх ОХУ болон АНУ-ын маргаан болон Крым “ОХУ-д дахин нэгдэн орсон” зэрэг хүчин зүйл нь Монгол улсыг өөрийнхөө “Аюулгүй” байдлын асуудлыг бодолхийлохгүй байж чадахгүй хэмжээнд хүргэсэн байна.

Монгол улс “Байнга төвийг сахих” бодлого хэрэгжүүлэх бодолхийлол

Хүйтэн дайны үеийн “Хэт нэг талыг барьсан” гадаад харилцааны бодлогоос ХХ зууны 90-ээд онд “Эвсэлд үл нэгдэх” гадаад харилцааны бодлого дурдан гаргасан, дахин Хятад Орос хоёр том гүрэнтэй гадаад харилцаагаа тэнцвэржүүлэхийн тулд “Туравдах хөрш”-ийн гадаад харилцааны бодлого дурдсан зэргээс Монгол улсын гадаад харилцааны бодлого алхам алхмаар боловсронгуй болж, нүдтэй бүхэнд илхэн харагдах амжилтад хүрсэн гэж хэлж болох юм. Өдгөө Монгол улс бас түүхэн дэх Швейцари, Түркменистан зэрэг хэдэн төвийг сахисан улсуудын үндэсний аюулгүй байдлаа хамгаалсан амжилттай туршлагаар лавлагаа болгож, ирээдүйд тулгарч болзошгүй олон улсын дарамтанд чиглүүлж “Байнгын төвийг сахих” бодлого дурдан гаргасан нь нэг цагийн хийрхэл огт биш, харин түүний “Эвсэлд үл нэгдэх, олон тулгуурт” гадаад харилцааны бодлогын үргэлжлэл болно. Монгол улс “Байнгын төвийг сахих” бодлого дурдаж гаргасан зорилго нь дараах мэт хэдэн талаар илэрч байна. Үүнд:

Юуны өмнө, Монгол улсын өөрийнхөө аюулгүй байдлыг хамгаалж чадна. Монгол улсын өвөрмөц газар зүйн байршил нь түүнийг Хятад болон Орос хоёр том гүрэнтэй хөршлүүлсэн байна. Монгол улсын үндэсний аюулгүй байдал нь түүний гадаад харилцаа болон цэргийн бодлогоороо хамгаалагддаг. Иймээс, Монгол улс түүний хөрш зэргэлдээ улсуудынхаа аюулгүй байдлыг маш анхаардаг. ЗХА-ийн байдал будлиантай болж, ирээдүйд энэхүү бүс нутагт дайн үүсэх боломж тасралтгүй нэмэгдэж байна. Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2016 оны

02-р сард Үндэсний телевизээр өгсөн сурвалжлагаар Монгол Улсын байнгын төвийг сахих бодлогоо тайлбарлахдаа: Байнгын төвийг сахина гэдэг бол дайны үед дайнд оролцохгүй, цэргийн эвсэлд элсэхгүй, харин энгийн үед энх тайван гадаад харилцааны бодлого хэрэгжүүлнэ гэжээ. Хэрэв Монгол улсын байнгын төвийг сахих байр суурийг олон улсын нийгэм хүлээн зөвшөөрсөн тохиолдолд, Монгол улс даруй том гүрний “шатар” биш болж, бусдад хязгаарлагдахгүй, өөрийнхөө аюулгүй байдлыг хамгаалахын төлөө нэн илүү цаг зарцуулахгүй болж, олон талын баялгаа ашиглаж өөртөө нэн их улс төр, гадаад харилцааны ашиг олох бөгөөд эрч хүчээ төвлөрүүлэн эдийн засгаа хөгжүүлэх болно.

Хоёрт, түүхэн дээр эндсэн замаараа эргээд явахаас зайлсхийж чадна. Түүхэн дээр, Гадаад Монгол Чин улсад 200 гаруй жил ноёрхогдсон. 1921 онд тусгаар тогтносны дараа дахин ЗХУ-ын хяналтанд орсон байна. Иймэрхүү түүхэн сургамжаас үүдэж, Монгол улс байнгын төвийг сахих улс болохоор тунхагласан нь, түүхэн дээр эндсэн замаараа дахин замнахаас сэргийлэхэд томоохон ач холбогдол өгөх болно. Нөгөө талаар, Хятад Орос одоогоор Монгол улстай өрсөлдөөний чанартай хамжилцааны харьцаатай, нэг талаар АНУ болон НАТО-гийн хүчний түрэн орохыг хүлээн авахын аргагүй бөгөөд нөгөө талаар бас өөрийнхөө нөлөөг ихсгэхийг хүсдэг. Эндсэн замаараа эргээд явахаас зайлсхийхийн тулд, Монгол улс урьдчилан сэргийлэх шаардлагатай болж, улс төр болон хуулийн арга хэмжээ авч эрсдлийг сэргийлэх хэрэгтэй болов.

Гурав, том гүрний харилцааг тэнцвэржүүлж, нэн их ашиг хүртэх ба хөгжлийн орон зай олж авна. Монголын гуравдах хөршийн бодлого нь Монгол улсын гадаад харилцааны орон зайг өргөтгөсөн боловч, бас Хятад Орос хоёр улсын сонор сэрэмжийг дээшлүүлж санааг нь зовоосон тул Монгол улс болон Хятад Орос хоёр том гүрэнтэй харилцаа хөгжүүлэхэд ашиггүй болсон байна. Байнгын төвийг сахих бодлого нь Хятад Орос хоёр том гүрний Монгол улсыг гуравдах улсад ашиглагдаж, хоёр том гүрний аюулгүй байдлыг нөлөөлөх эргэлзэл болон санаа зоволтыг арилгаж, хоёр том гүрэнтэйгээ үх талын хамтын ажиллагаа хөгжүүлэхэд нэн сайн байдаг. Монгол улс 1990 оноос нааш, “гаадаадын хандив тусламж”-ийг ихээхэн хүртэж, эдгээр асуудал нь зарим олон улсын асуудал дээр нэг талыг сонгохгүй байхын аргагүй болгож, зохих хэмжээний “Гадаад харилцааны дарамт”-тай болсон байна. “Байнгын төвийг сахих улс” болсоор Монгол улс даруй дэлхийн улсуудтай харилцах дунд нэг “халхавч бамбай”-тай болж, түүнээс салж гарч чадах болно.

Дөрөв, Монгол улсын бүс нутгийн аюулгүй байдлыг хамгаалах ажил дахь үүргийг дээшлүүлнэ. Монгол улсын сүүлийн жилүүдэд дурдан гаргасан ЗХА-ийн аюулгүй байдлын механизмыг хөрш зэргэлдээ улсууд санал нэгтэй хүлээн зөвшөөрөв. Байнгын төвийг сахих гадаад харилцааны бодлого хэрэгжүүлснээр, Монгол улсын олон улс дахь итгүүлэх хүчнийг улам дээшлүүлж, Солонгос Япон, Япон БНСУ зэрэг бүс нутгийн маргааныг зохицуулах ажилд Монгол улс нэн их үүрэг гүйцэтгэж, олон улс дахь дүр төрх байр сууриа дээшлүүлж, Монгол улс олон улсын хамжилцаан дунд ашиг хүртэхэд тустай юм.

Тав. олон улсын нийгмийн анхаарал, хөрөнгө оруулалтыг татах болно. Сүүлийн жилүүдэд, олон улсын зах зээлийн том оврын барааны үнийн уналт болон Хятадын эдийн засгийн удаашрлын нөлөөллөөс болж, Монгол улсын эдийн засаг хүндрэлд орсон байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж эдийн засгаа хөгжүүлэх бол Монгол улсын эн тэргүүний чухал зорилт болно. Байнгын төвийг сахисан улс болбол Монгол улсын хөрөнгө оруулалтын орчныг ихээр сайжруулж, гадаадын хөрөнгийг Монгол улсын зах зээлд зоригтой оруулж ирж эдийн засгаа сэргээхэд ихээхэн ашигтай гэдэг нь эргэлзээгүй юм.

Монгол улсын гадаад харилцааны бодлогын өөрчлөлт Хятад, Монголын харилцаанд үзүүлэх нөлөө

Монгол улс Хятад Орос хоёр том гүрний дунд оршиж, газар зүйн байршил нь өвөрмөц болохоор түүний гадаад харилцааны хөгжил нь БНХАУ, АНУ, ОХУ, Япон зэрэг дэлхийн чухал том гүрнүүдийн нөлөөллийг хүртэх нь зайлшгүй юм. Монгол улс “Байнгын төвийг сахих бодлого” зарласан нь түүний “Эвсэлд үл нэгдэх гадаад харилцааны бодлогын” үргэлжлэл гэж хэлж болох боловч, Хятадад авч хэлбэл ойрын хугацаанд их нөлөө үзүүлэхгүй, гэхдээ алс ирээдүйд зохих хэмжээний идэвхтэй ба назгай нөлөө гарах болно.

Аюулгүй байдлын үүднээс авч үзвэл, Хятад, Монгол хоёр улс 4700 гаруй км урт хилийн шугамтай, Хятад орон энэхүү умард хөршөөсөө аюулгүй байдлын ашиг болох “Хоёрдахь даатгал” олох болно. Монгол улсын байнгын төвийг сахих бодлогын байр суурийг олон улсын нийгэм хүлээн зөвшөөрсөн тохиолдолд, хүйтэн дайны үеийнх шиг ЗХУ-ын цэрэг Хятад Монголын хил дээр байрлах байдал дахин үүсэхгүй болно.

Гэтэл стратегийн үүднээс авч үзвэл, Монгол улсын өөрийнх нь хүсэлт болон уг бүс нутгийн харилцаанаас магадлахад, Монгол улс ЗХА-ийн гадаад харилцааны дэглэмд нэн их үүрэг гүйцэтгэж, Хятадад үзүүлэх нөлөө нь Монгол улс болон эдгээр улс ба олон улсын байгууллагын хоёр тал болон олон талын интерактив, ялангуяа бүс нутгийн дэглэм тогтворгүй байх үеэс шийдвэрлэгдэх болно.

Эдийн засгийн үүднээс авч хэлбэл, Монгол улс “Төвийг сахисан улс”-ын байр суурь болон нөлөөгөөрөө бусад улсуудтай нэн өргөн хамтын ажиллагаа өрнүүлэх нь үнэндээ “хоёрдахь нээлт” болж, энэ чимээгээр хүрэлцэн ирэх гадаадын хөрөнгөтэй аж ахуйн нэгжүүд нэмэгдэх хандаш гарч, Монгол улсын эдийн засагт шинэ тохиол олгох болно. Энэ нь Хятадын гадаадад хөрөнгө оруулах болон “Нэг бүс нэг зам”-ын санаачлагыг Монголд хэрэгжүүлэхэд тохиол болох мөртөө бас зохих өрсөлдөөнд тулгарах болно.

НОМ ЗҮЙ

1. Монгол улсын Гадаад харилцааны яам “Монгол улсын гадаад харилцааны хөх ном”, 2006 он, Улаанбаатар.
2. Монгол улс бол манай улсын хамгийн чухал умард хөрш. Ринмин сайт, 2015 оны 10-р сарын 21.
3. Ж.Баясах “ЗХА-ийн аюулгүй байдлын стратегийн тулгамдсан асуудал”, ZANBULING, 2016 оны 1-р улирал.